



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАРЬЦАА ХӨРӨНГӨӨС 47.2 САЯ
ТӨГРӨГИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

Аудитын сэдэв:

**ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮР ДҮН**

Аудитын код:

ӨМА-2023/43-2-ШТА-ГА




**Даланзадгад сум
2023 он**

Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар 334.4 мянган га талбайд 49 ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэлтэй байна. Энэ нь нийт нутаг дэвсгэрийн 2.0 хувийг эзэлж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид аймгийн 15 сумаас 12 суманд үйл ажиллагаагаа явуулж байна. Булган, Даланзадгад, Сэврэй сумдад ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоогүй байна.

График-1: Аймгийн ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон ААН-ийн тоо, талбайн хэмжээ, газарүйн байршил



Эх сурвалж: Ашигт малтмалын газрын тосны газрын статистик мэдээнээс

18 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч БОМТ-г батлуулаагүй байна.

16 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа явуулаагүй байна.

73.1 Сая төгрөг сумдын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрсөн байна.

29.0 Сая төгрөг барьцаа
хөрөнгийн дансанд дутуу
төвлөрүүлсэн байна.

АУДИТААР

13 Албан шаардлагыг
12 сум, БОАЖГ-т
хүргүүлэв.

10 Суманд **29.0** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

БҮЛЭГ-1: Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сумын Засаг дарга санал оруулдаггүй байна.





Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дахь заалт, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.1 дахь заалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахаар заасан байдаг.



Дээрх хууль журамд заасан батлагдсан маягыг өөрчилж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтэн нар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянаж, зөвшөөрөл олгож баталгаажуулсан байна.

Энэ нь сумын Засаг дарга нарын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд санал оруулах боломжийг хязгаарлаж байна.

Зураг 1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн БОХТ-ний батлагдсан маягт, түүнийг өөрчилсөн байдал



Энэ нь сумдын Засаг дарга байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд санал оруулах боломжийг хязгаарлах, төрийн байгууллагын шат дамжлагыг нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг буй болгож байна.

АУДИТААР 12

Суманд дээрх 2020-2022 оны баримт бичгийг сумын ЗДТГ болон БОАЖГ-ын архивд бүрэн бүрдэлтэй хүлээлгэн өгөх албан шаардлага хүргүүлсэн.

Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 29.0 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны тушаалаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг баталсан. Энэхүү журамд заасан тусгай данс нь сумдад байдаггүй бөгөөд барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж байна.



Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.8, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.3 дахь заалтад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх тухай заасан байдаг.

102.1

Сая төгрөгийг (аудитын явцад ирүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн БОМТ-өөр) төвлөрүүлэхээр байна.

73.1

Сая төгрөгийг сумын барьцаа хөрөнгийг дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 2.3.5 дахь заалтын дагуу алданги тооцоогүй байна.


График-2: Барьцаа хөрөнгийг дутуу төвлөрүүлсэн 29.0 сая төгрөгийн задаргаа



2020 онд
6.9%-г дутуу
төвлөрүүлсэн
байна.



2021 онд
19.8%-г дутуу
төвлөрүүлсэн
байна.



2022 онд
51.4%-г дутуу
төвлөрүүлсэн
байна.



Нийт төвлөрүүлэх дүн



Дутуу төвлөрүүлсэн дүн

Цаашид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлэх байх шаардлагатай байна.


АУДИТААР 29.0

Сая төгрөгийн (10 суманд) барьцаа хөрөнгийн бүрэн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

БҮЛЭГ-2: БҮЛЭГ 2. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ТУСГАЙ ДАНСНААС 47.2 САЯ ТӨГРӨГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Төвлөрүүлсэн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулаагүй байна.


Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 2020-2022 онд 151 (давхардсан тоогоор) хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж, 16 (давхардсан тоогоор) ААН үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнд:



Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийг Хүрмэн, Мандал-Овоо сумын байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид шинээр томилогдсон гэх шалтгаанаар мэдэхгүй байх зөрчил аудитын явцад илэрсэн.

Энэ нь төрийн захиргааны байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, ажлын уялдаа хангалтгүй байгааг харуулж байна.

График-3: Барьцаа хөрөнгийг 2020-2022 онд зарцуулсан байдал.



Дээрх зарцуулалт нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

АУДИТААР 6

Сумын Засаг даргад нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Сумдын Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан Байгаль орчны менежментийг төлөвлөгөө боловсруулах, хянаж батлах, тайлагнах журамд заасан загвар, маягтын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргасан байна.




Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансанд байршуулах мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг төрийн сангийн мэргэжилтэн жилийн эцэст сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.

Энэ нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 4.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь тус дансанд баталгааны 50 хувийн мөнгөн хөрөнгө орсон эсэхэд тавих хяналтыг сулруулж байна.


Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй менежментийн төлөвлөгөө батлуулсан 76 ААН цар тахлаас шалтгаалан техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай хайгуулын ажил гүйцэтгээгүй байна.

Аудитын явцад дараах 2 асуултаар 6 сумын 40 иргэд, малчдаас санал асуулга авахад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар мэдлэг, мэдээллээр хангагдахгүй байгааг харуулж байна. Үүнд:

1. Танай сумын нутаг дэвсгэрт хэдэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байдаг талаар мэдэх үү?



2. Тухайн аж ахуйн нэгж хэдий хэмжээний нутаг дэвсгэрт хайгуул хийж байгаа талаар мэдэх үү?



Иймд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн талаар мэдээллийг Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 , 12.2.2 дахь заалтыг хэрэгжүүлэн, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах талаар сумдын Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.

АУДИТААР 12

Сумын Засаг даргад холбогдох албан тушаалтнуудын хууль, эрх зүйн мэдлэгийг сайжруулах, байгаль холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.